

## УЛААНБААТАР ХОТОД ШИЛЖИН ИРЭГСДИЙН АЖИЛ ЭРХЛЭЛТЭНД НӨЛӨӨЛӨГЧ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН ШИНЖИЛГЭЭ

Б.Нарантулга  
Эдийн засгийн магистр, МУИС, ЭЗС,  
ХАССТ-ийн судлаач/ ЭША

*Хот хөдөөгийн хөгжлийн ялгаа, үүнээс улбаалан хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөн нэмэгдэж, хотжих хөдөлгөөн эрчимтэй явагдаж байгаа энэ үед шилжих хөдөлгөөнд оролцоход хүргэж байгаа хамгийн гол шалтгаан нь ажил эрхлэх, амьжиргаагаа дээшлүүлэх явдал болоод байна.*

*Ажил эрхлэлт нь хүн амын орлого, хэрэглээ, боловсрол, эрүүл мэндийн байдал, цаашлаад амьжиргааны түвшинд шууд нөлөө үзүүлдэг хүчин зүйл учраас шилжигсдийн хувьд ажил эрхлэлтийн байдал ямар байгаа нь нэлээд анхаарал татсан асуудал юм.*

*Судлаач энэхүү ажилдаа шилжих хөдөлгөөнд оролцогчдыг хүлээн авч буй хамгийн гол бүс болох Улаанбаатар хотод шилжин ирсэн хүн амын ажил эрхлэлтийн байдал ямар байна, ажил эрхлэлт тэдний ахуй, амьдралд хэрхэн нөлөөлж байна гэсэн асуултанд хариулт өгөхийг зорьсон байна.*


*Түүнчлэн 2000 онд Монгол Улсын Засгийн Газрын хүсэлтээр НҮБХАС санхүүгийн дэмжлэг үзүүлэн МУИС-ийн ХАССТ-өөс явуулсан “Монгол Улсын Хүн амын дотоод шилжих хөдөлгөөний микро түвшний судалгаа”-ны мэдээллийг ашиглан гүнзгийрүүлсэн шинжилгээ хийж, нийслэлд шилжин ирсэн хүн амын ажил эрхлэлтэнд нөлөөлөгч хүчин зүйлүүдийг тодорхойлжээ.*

*...”Хүн ам, байгаль орчин, хөгжлийн асуудал нь асар өргөн цар хүрээтэй, үнэндээ бол хотжилттой холбогдсон асуудал юм. Өөрөөр хэлбэл, “хүн төрлөхтний оршин суух явдал дахь амьдралын чанарыг сайжруулах” нь хотжилтын хурдац, хотын хүн амын хэт их төвлөрөл, түүнээс үүсэх үр дагаврууд зэрэг асуудлыг зүй ёсоор хөндөхөд хүргэдэг билээ. (Стамбул хотноо хуралдсан “Хүн төрлөхтний суурьшил” НҮБ-ын бага хурлын тунхаглалаас)*

Монгол Улсын хүн амын шилжих хөдөлгөөн нь улс орны түүх, нийгэм, эдийн засгийн хөгжлийн үеүдтэй нягт холбоотой байсаар ирсэн бөгөөд түүний шууд үр дагавраар хүн амын байршил, тархалт, тоо хэмжээ, нас, хүйсийн бүтэц болон бусад үзүүлэлтүүдэд өөрчлөлт гарч байлаа.

Манай улсын хувьд хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөн нь цоо шинэ асуудал биш бөгөөд, 1940-өөд оноос нийслэл болон төв суурин газруудад засаг захиргааны нэгжүүд төвлөрч, үйлдвэр, аж ахуйн нэгжүүд олноор байгуулагдан, тэдгээрт ажиллах хүч шаардагдаж эхэлснээр хөдөөнөөс хотод шилжин суурьших явдлыг дэмжиж, улмаар хотод шилжин суурьших нөхцлийг бүрдүүлсэн юм. (“Хүн ам ба Хөгжил” Дээд хэмжээний уулзалт, 2001 он) Тухайн үед шилжих хөдөлгөөнийг хянан, ажлын байрны эрэлт хэрэгцээтэй уялдуулж байснаас ажиллах хүчний тархалт, байршилтын асуудал зүй зохистойгоор шийдвэрлэгдэж байлаа. (Хүн Ам ба Хөгжил Дээд хэмжээний уулзалт, 2001 он)

Харин зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэнээр нийгэм, эдийн засгийн тогтолцооны өөрчлөлт, бүс нутгийн хөгжлийн ялгавартай байдлаас хамааран төвийн бүсийн аймаг, хотууд, ялангуяа Улаанбаатар хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөн эрчимтэй явагдаж, 1995-2000 оны байдлаар шилжих хөдөлгөөнд оролцсон 10 хүн тутмын 6 нь Улаанбаатар хотод оршин сууж, тус хотын 5 ба түүнээс дээш насны нийт хүн амын 15 орчим хувийг бүрдүүлжээ. (ҮСГ, 2001 он)



**Эх сурвалж:** УСГ, Монгол Улсын Хүн ам, орон сууцны 2000 оны улсын тооллого, Статистикийн эмхэтгэл

Зураг 1-с харахад Баруун болон Төвийн бүсийн хүн ам шилжих хөдөлгөөнд хамгийн ихээр өртсөн бөгөөд Улаанбаатараас бусад бүх бүс нутагт шилжин явсан хүн ам нь шилжин ирснээсээ эрс их байна.

Улаанбаатар хотод хүн ам ихээр шилжин ирж, суурьшиж байгаатай холбоотойгоор хүн амын жилийн дундаж өсөлт бусад бүсээс харьцангуй өндөр байна. (Зураг 2)

Улмаар шилжих хөдөлгөөний энэхүү урсгал ойрын 5 жилд буурахгүй, зөвхөн Улаанбаатар хотод л цэвэр шилжих хөдөлгөөний эерэг утга ажиглагдах болжээ. (УСГ, 2002)

ХАССТ-с явуулсан судалгааны үр дүнгээс харахад, судалгаанд хамрагдсан нийт хүн амын 1/4 орчим нь дахин шилжих хүсэлтэй байгаа ба тэдний 40 орчим хувь нь нийслэлд шилжин суурьшихаар төлөвлөж байгаагаас хүн амын ирээдүйн шилжилтийн хамгийн гол бүс нь Улаанбаатар хот хэвээрээ байх нь гэж дүгнэж болно. Энэ нь Улаанбаатар хотын татах хүчин зүйлүүд буюу дэд бүтэц, харилцаа, холбооны хөгжил, эрүүл мэнд, боловсролын үйлчилгээний хангамж зэрэг хүчин зүйлээс хамаарч байна.

Тухайлбал, 2000 оны байдлаар Монгол улсын нэг хүнд ногдох ДНБ жилд 420 мянган төгрөг байхад, Улаанбаатар хотын оршин суугчдын хувьд энэ үзүүлэлт 680 мянга орчим төгрөг байгаа ба Дархан-Уул, Орхон аймгийг оруулахгүйгээр авч үзэхэд бусад аймгуудаас 2.3 дахин өндөр үзүүлэлт байна. (УСГ, 2002)

Хот руу чиглэсэн энэхүү “их нүүдэлтэй” холбоотойгоор шийдлээ хүлээх болсон олон асуудлын нэг нь хотын хөдөлмөрийн зах зээлд их хэмжээгээр нийлүүлэгдэж байгаа ажиллах хүчийг шингээх буюу шилжин ирэгсдийг ажлын байраар хангах, цаашлаад амьдралын баталгаатай болгох асуудал юм.


*Баруун бүс нутагт: Ховд, Увс, Завхан, Баян-Өлгий, Говь-Алтай, аймгууд*

*Хангайн бүс нутагт: Баянхонгор, Хөвсгөл, Булган, Архангай, Өвөрхангай, Орхон аймгууд*

*Төвийн бүс нутагт: Сэлэнгэ, Төв, Дундговь, Дорноговь, Өмнөговь, Говьсүмбэр, Дархан-Уул аймгууд*

*Зүүн бүс нутагт: Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймгуудыг оруулав.*

Зураг 2. 1995-2000 оны хүн амын жилийн дундаж өсөлтийн түвшин, бүс нутгаар



**Эх сурвалж:** ҮСГ, Монгол Улсын Хүн ам, орон сууцны 2000 оны тооллого, Статистикийн эмхэтгэл

Хүн амын хотод шилжин суурьших гол шалтгаан нь ажил эрхлэлт болоод байгаа (ХАССТ, 2000) энэ үед Улаанбаатар хотын хүн амын ажил эрхлэлтийн түвшин хөдөөгийн хүн амын болон улсын дундаж ажил эрхлэлтийн түвшинтэй харьцуулахад доогуур түвшинд байгаагаас гадна (Хүснэгт 1) бүртгэлгүй буюу далд ажилгүйдэл, нийгмийн хангамж, хамгаалал муутай албан бус секторт ажиллагсад нэмэгдэх болов. (ОУБХ, 2001)

Хотжилтын түвшинтэй уялдан ажил эрхлэлтийн байдалд гарч буй нэг өөрчлөлт бол ажиллагсдын эдийн засгийн салбарын бүтэц бөгөөд бүс нутгууд дахь хотжилтын түвшин нэмэгдэхийн хэрээр анхдагч<sup>1</sup> салбарт ажиллагсдын хувийн жин буурч, хоёрдогч<sup>2</sup>, гуравдагч<sup>3</sup> салбаруудад ажиллагсдын хувийн жин өсөж байгаа явдал юм. Ерөнхийдөө, Улаанбаатар хотод хүн амын тоо буюу хэрэглэгчдийн тоо нэмэгдэж, зах зээлийн хүрээ тэлсээр байгаа нь хоёрдогч ба гуравдагч салбаруудын хөгжил эрчимтэй явагдахын үндэс болж байна.

Хотжилтын түвшин хамгийн багатай Баруун бүсэд анхдагч буюу хөдөө аж ахуйн салбарт ажиллагсдын эзлэх хувь өндөр (74 хувь) байхад, эсрэгээр хотжилтын түвшин өндөр Улаанбаатарт хамгийн бага байна. Улаанбаатар хотын ажиллагсдын 70.5 хувь нь гуравдагч, 2.2 хувь нь анхдагч, үлдсэн хувь нь хоёрдогч салбарт ажиллаж байна. (А.Солонго, Б.Мөнхжаргал, 2003)

Хүснэгт 1. Ажиллах хүчний үзүүлэлтүүд, бүсээр, 2002 он (хувиар)

Үзүүлэлтүүд	Бүсүүд					Улсын дүн
	Хангай	Баруун	Төв	Зүүн	Улаанбаатар	
Ажиллах хүчний оролцооны түвшин*	71.6	74.3	66.6	63.4	50.4	62.7
Ажил эрхлэлтийн түвшин**	68.3	70.9	64.5	60.8	49.4	60.5
Ажилгүйдлийн түвшин***	4.7	4.4	3.1	4.7	2.0	3.4

Тэмдэглэл: \* 15-түүнээс дээш насны нийт хүн амд ажил эрхэлж байгаа болон ажилгүй байгаа нийт хүн амын эзлэх хувь.

\*\* - Ажиллагсад ба 15 ба түүнээс дээш насны хүн амын харьцаа.


\*\*\* - Бүртгэлтэй ажилгүйчүүд ба эдийн засгийн идэвхтэй хүн амын харьцаа.

Эх сурвалж: ҮСГ, Монгол Улсын Статистикийн эмхэйтгэл, 2002 он

Улаанбаатар хотын хөдөлмөрийн насны хүн амын хувийн жин шилжих хөдөлгөөний нөлөөгөөр өндөр байгаа боловч (ҮСГ, 2002) ажиллах хүчний оролцооны түвшин хамгийн доогуур байгаа нь эдийн засгийн идэвхгүй хүн ам, тухайлбал, хөдөлмөрийн насны суралцагсад болон хөдөлмөрийн чадваргүй хүн амын хувийн жингийн өндөр түвшинтэй холбоотой юм. Түүнчлэн нийслэлд бүртгэлтэй ажилгүйчүүдийн түвшин улсын дундаж болон бусад бүсүүдээс доогуур байгаа нь оршин суугчдын эдийн засгийн идэвхи сул байгааг харуулж байна.

Бүртгэлтэй ажилгүйдлийн түвшнээр Улаанбаатар хамгийн бага байгаа ч тооцоологдсон ажилгүйдлийн түвшингээр авч үзэхэд 20.2 хувь буюу Зүүн бүсийн дараа орж байна. Энэ нь нийслэлд бодит ажилгүйдэл өндөр хувьтай байгааг харуулж байна, нөгөө талаар хөдөө орон нутагт эдийн засгийн бүтцийн бүтээмж багатай мал аж ахуйн салбар давамгайлсан байдагтай холбоотой юм. (А.Солонго, Б.Мөнхжаргал, 2003)

Зураг 3. Ажилгүйдлийн түвшин, хотын хүн амын эзлэх хувь, аймаг нийслэлээр 2000 оноор



Эх сурвалж: ҮСГ, ХАОСТ, Хүн амын эдийн засгийн идэвхи: Сэдэвчилсэн судалгаа, 2001 он

<sup>1</sup>Анхдагч: ХАА, <sup>2</sup>Хоёрдогч: Аж үйлдвэр, <sup>3</sup>Гуравдагч: Үйлчилгээний чиглэлийн салбарууд

Ерөнхийдөө хүн амын ажилгүйдлийн түвшин ба хотжилтын түвшин хоёрын хооронд эерэг хамаарал ажиглагдаж байна. (Зураг 3) Өөрөөр хэлбэл, хотын хүн амын хувийн жин өсөх нь араасаа ажилгүйдлийн өндөр түвшнийг дагуулж байна гэсэн үг юм. Үүнийг нэг талаас олноор ирж суурьшиж буй ажиллах хүчийг ажлын байраар бүрэн хангаж чадахгүй байгаатай, нөгөөтэйгүүр эдийн засгийн идэвхитэй хүн амын хувийн жингийн хэт хурдан өсөлттэй холбон тайлбарлаж болох юм.

### **Судалгааны ажлын зорилго, шинэлэг байдал**

Энэхүү судалгааны ажил нь дараахь үндсэн зорилготой. Үүнд:

- Улаанбаатар хотод шилжин ирсэн хүн амын ажил эрхлэлтийн байдлыг гүнзгийрүүлэн судалж, ажил эрхэлж байгаа болон ажил эрхлэхгүй байгаа хүн амын ахуй амьдралд гарсан өөрчлөлтийг харьцуулан дүгнэлт хийх;
- Шилжин ирсэн хүн амын ажил эрхлэлтэнд нөлөөлж байгаа хүчин зүйлүүдийг тодорхойлох, тэдгээр хүчин зүйлүүдийн хамаарлыг судлах.

*Судалгааны шинэлэг байдал:*

Шилжих хөдөлгөөн, хотжилт, ажил эрхлэлт зэрэг асуудлын талаар хийгдсэн судалгаа, эрдэм шинжилгээний ажлууд олонтаа тохиолддог. Гэвч шилжих хөдөлгөөн ба ажил эрхлэлтийн асуудлыг судалгааныхаа гол объект болгон, тэдгээрийн уялдаа холбоо, шилжигсдийн ажил эрхлэлтийн байдал, түүнд нөлөөлөгч хүчин зүйлсийн талаар нарийвчлан хийсэн судалгааны ажил өнөөг хүртэл хийгдээгүй байна.

Түүнчлэн шилжигсдийг хүлээн авагч, хөдөөнөөс хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөнийг тодорхойлогч гол бүс болох Улаанбаатар хотод шилжин ирэгсдийн ажил эрхлэлтэнд нөлөөлөгч хүчин зүйлсийн судалгааг хийснээр Монгол Улсын дотоод шилжих хөдөлгөөнд оролцогчдын нийтлэг дүр төрхийг тодорхой хэмжээгээр харуулж чадна гэж үзсэн болно.

### **Ойлголт, тодорхойлолтууд**

*Шилжих хөдөлгөөн*

Энэхүү ойлголтоор тухайн аймаг, хотын хил хязгаарыг даван өөр аймаг, хотод шилжин суурьшсан хөдөлгөөнийг авч үзсэн.

*Шилжигч*

Шилжих хөдөлгөөнд оролцогч буюу сүүлийн 5 жилийн хугацаанд Улаанбаатар хотод шилжин суурьшсан хүмүүсийг хамруулж байна.

*Ажил эрхэлж байгаа хүн ам*

Сүүлийн долоо хоногт ажил эрхэлсэн эсэхээр шалгуур болгон тодорхойлсон. Сүүлийн 7 хоногт ядаж нэг өдөр ажил эрхэлсэн буюу бараа, үйлчилгээ бий болгоход оролцсон хүмүүсийг ажил эрхэлж байгаа хүн амд багтаан үзэв.

Хүн ам зүйн хүчин зүйл. Энэхүү ойлголтыг дараахь үзүүлэлтүүдээр илэрхийлнэ.

- Нас

Шилжин ирэгсдийн насыг ажил эрхлэлтийн байдалтай холбон 15-24, 25-44, 45-ба түүнээс дээш насныхан гэж ангилсан.

- Өрхийн ам бүлийн гишүүдийн тоо

Тухайн шилжин ирсэн өрхөд амьдарч байгаа нийт хүний тоо бөгөөд, 1, 2-5, 6-9, 10 буюу түүнээс дээш гэсэн 4 ангиллаар авч үзэв.

- Боловсролын түвшин

Хүн амын боловсролын түвшин нь ажил эрхлэлтийг шууд тодорхойлогч хэмжигдэхүүн юм. Шилжин ирсэн хүн амыг боловсролын түвшнөөр нь Бүрэн дундаас дээш, Бүрэн дунд ба түүнээс доош, Боловсролгүй гэсэн 3 бүлэгт ангилаад, бүлэг бүрт хамаарах категориудыг нэгтгэн үзсэн.

*Нийгэм, эдийн засгийн хүчин зүйл:* Энэхүү ойлголтод дараахь үзүүлэлтүүдийг оруулсан.

- Тухайн өрхийн нэг хүнд ногдох сарын хэрэглээний түвшин

Тухайн өрхийн нэг хүнд ногдох сарын хэрэглээний түвшинг 1998 онд ҮСГ-аас явуулсан “Хүн амын амьжиргааны түвшний судалгаа”-с тодорхойлсон нэг хүнд ногдох сарын хэрэглээний түвшнээр ангилан авч үзсэн. Үүнд:

11005 төгрөгөөс доош бол	Нэн ядуу
11006-14674 төгрөг:	Ядуу
14675-22012 төгрөг :	Ядуу бус бага орлоготой
22013-33018 төгрөг :	Ядуу бус дундаж орлоготой
33019 төгрөгөөс дээш :	Ядуу бус өндөр орлоготой

- Шилжин ирэхээс өмнөх байршил

Улаанбаатар хотод шилжин ирэхээс өмнө сууж байсан газрын байршил бөгөөд Нийслэл, Аймгийн төв, Тосгон, Сумын төв, Хөдөө, Гадаад гэсэн ангиллаар орсон.

- Шилжилтийн шалтгаан

Тухайн шилжигчийн Улаанбаатар хотод шилжин суурьшихад голлон нөлөөлсөн шалтгааныг авч үзсэн ба ажил эрхлэх, бусад гэсэн 2 ангиллаар оруулав.

- Орон сууцны нөхцөл

Энэхүү үзүүлэлт нь ажлын байртай болоход нөлөөлөгч нэг хүчин зүйл гэж таамагласны үндсэн дээр загварт оруулсан. Өрхийн амьдарч буй сууцны төрөл, зориулалт халаалт, ундны ус, гэрэлтүүлэг, бие засах газрын төрөл зэрэг ахуйн нөхцлийн 9 үзүүлэлтийг нэгтгэн индекс зохиож, орон сууцны нөхцөл сайн, дунд зэрэг, муу гэж ангилан тодорхойлов.

- Бүртгэлийн статус

Улаанбаатар хотод шилжин ирээд засаг захиргааны шилжүүлэг хийлгэсэн эсэхээр шалгуур болгон авсан ба нэг талаас шилжигчдийг бүртгэн авах үндсэн нөхцөл нь ажлын байрны баталгаа, нөгөө талаас бүртгэл нь ажлын байртай болоход нөлөөлнө гэж үзээд энэ үзүүлэлтийг авсан.

*Хамаарах хувьсагч*

Таамаглагдаж буй хүчин зүйл буюу ажил эрхэлж буй байдал гэсэн ойлголтоор илэрхийлэгдэж байна.

### *Үл хамаарах хувьсагч*

Тухайн үзүүлэлтэнд нөлөөлнө гэж тааварлагдаж байгаа хүчин зүйлүүд болох хүн ам зүй, нийгэм, эдийн засгийн хүчин зүйлс юм.

### *Хамаарах байдал*

Үзүүлэлтүүдийн хамаарах байдал гэдэг нь нэг үзэгдлийн аливаа нэг утгад нөгөө үзүүлэлтийн тодорхой нэг утга харгалзах явдлаар тодорхойлогдоно. Өөрөөр хэлбэл хамаарах хувьсагч нь үл хамаарах хувьсагчдаас тодорхой хэмжээгээр хамааралтай байна гэсэн үг юм.

## **Шинжилгээний аргууд ба мэдээллийн эх үүсвэр**

Энэхүү ажилд 2000 онд МУИС-ийн Хүн Амын Сургалт Судалгааны Төвөөс явуулсан “Монгол Улсын Хүн амын дотоод шилжих хөдөлгөөний микро түвшний судалгаа”-г хоёрдогч мэдээллийн эх үүсвэр болгон ашиглаж, шинжилгээ хийв. Түүнчлэн 1989, 2000 оны тооллогуудаар цуглуулагдсан мэдээлэл, 2000 оны хүн ам, орон сууцны тооллого дээр үндэслэн гаргасан сэдэвчилсэн судалгаанууд болон бусад холбогдох эрдэм шинжилгээний ажлууд, онол болон арга зүйн материалуудыг ашигласан.

Уг ажилдаа математик аргууд, шинжлэх ухааны хийсвэрлэлт, харьцуулалт, анализ, график тооцоо, эконометрик, статистик аргууд болон судалгааны мэдээлэлд статистик шинжилгээ хийх SPSS багц программыг ашиглав.

Улаанбаатарт шилжин ирсэн хүн амын ажил эрхлэлтэнд нөлөөлөгч хоёр хүчин зүйлийн шинжилгээг  $\chi^2$ -ийн аргад тулгуурласан дурын хэмжээс бүхий хүснэгтүүдийн тооцоонд ашиглагддаг хамаарлыг тодорхойлох Cramer's V гэсэн нэрлэсэн хэмжигдэхүүнийг ашиглан тодорхойлов.

Ажил эрхлэлтийн байдал гэсэн хамаарах хувьсагч нь тийм, үгүй гэсэн хоёр сонголттой Dummy хувьсагч, үл хамаарах хувьсагчид нь Dummy болон нэрлэсэн түвшний хувьсагчууд учраас ажил эрхлэлтэнд нөлөөлөгч хүчин зүйлийн шинжилгээг ложистик регрессийн загварыг ашиглан үнэлсэн. Үүний үндсэн дээр хүн ам зүйн хүчин зүйлийн ажил эрхлэлт дэх нөлөөлөл, хүн ам зүй ба нийгэм, эдийн засгийн үзүүлэлтүүдийн ажил эрхлэлт дэх нөлөөллийг тодорхойлогч загваруудыг гаргалаа.

## **Мэдээллийн хязгаарлагдмал байдал**


Шилжин ирсэн хүн амын ажил эрхлэлтэнд нөлөөлөгч хүчин зүйлүүдийг тодорхойлохдоо хүн ам зүйн болон нийгэм, эдийн засгийн хүчин зүйлс гэсэн үл хамаарах хувьсагчдыг сонгосон. Гэвч хоёрдогч мэдээллийн эх үүсвэрийг ашигласнаас үл хамаарах хувьсагчууд тодорхой асуултуудын хүрээнд хязгаарлагдмал байдлаа сонгогдсон тул хүссэн үр дүнгээ гаргах боломж хязгаарлагдмал байв. Өөрөөр хэлбэл, судалгааны асуулгаар цуглуулагдсан мэдээллүүдийг ашиглан ажил эрхлэлтэнд нөлөөлөгч үзүүлэлтүүдийг тодорхойлсон болно.

## Судалгааны логик хүрээ, таамаглал

Энэхүү ажлын судалгаа, шинжилгээний хүрээ нь 2000 онд МУИС-ийн Хүн Амын Сургалт Судалгааны Төвөөс НҮБ-ын Хүн Амын Сангийн санхүүгийн дэмжлэгтэйгээр явуулсан “Монгол Улсын Хүн амын дотоод шилжих хөдөлгөөний микро түвшний судалгаа” болон уг сэдэвтэй холбоотой эрдэмтэд, судлаачдын онол, таамаглал, судалгааны ажлууд, ном, эрдэм шинжилгээний бусад бүтээлүүд, өөрийн санал, дүгнэлт дээр үндэслэгдэн боловсруулагдсан болно.

Шинжилгээний хүрээнд шилжин ирсэн хүн амын ажил эрхлэлтийн байдал гэсэн хувьсагчийг сонгож, хүн ам зүйн болон нийгэм, эдийн засгийн хүчин зүйлсэд хамаарах дараахь хувьсагчуудаас хамааруулан шалтгааны загвараар шинжилгээг хийлээ. Уг загварыг схемээр харуулбал:

Зураг 4. Улаанбаатар хотод шилжин ирэгсдийн ажил эрхлэлтийн шалтгааны загвар



Судалгаанд дараахь таамаглалуудыг дэвшүүлсэн. Үүнд:

1. Шилжин ирэгсдийн ажил эрхлэлтийн байдалд нас, боловсролын түвшин нь голлон нөлөөлөгч хүчин зүйлүүд юм.
2. Гэр бүлийн хэмжээ, шилжилтийн шалтгаан, өрхийн сарын хэрэглээний нэг хүнд ногдох түвшин, орон сууцны нөхцөл, бүртгэл зэрэг үзүүлэлтүүд нь хамаарах хувьсагчид дунд зэргийн нөлөө үзүүлнэ.
3. Сонгосон хүн ам зүйн болон нийгэм, эдийн засгийн үзүүлэлтүүд нь ажил эрхлэлтийн байдлыг тайлбарлах чадвар сайтай хувьсагчид юм.
4. Эрэгтэй, эмэгтэй хүйсийн хувьд үл хамаарах хувьсагчууд ялгаатай байдлаар тодорхойлогдоно.




## Улаанбаатар хотод шилжин ирэгсдийн ажил эрхлэлтийн байдал

*Шилжин ирэгсдийн ажил эрхлэлтийн байдал:*

Энэхүү судалгаанд шилжин суурьшсан нутгууд болох Улаанбаатар хот, Дархан-Уул, Төв аймагт шилжин ирсэн 15-64 насны 1765 хүн хамрагдсаны 885 нь буюу тэн хагас нь Улаанбаатар хотод шилжин суурьшигчид байлаа.

Эдгээр хүн амын 56.7 хувь нь эмэгтэй, 43.3 хувь нь эрэгтэй хүн ам байгаа ба 45-49 насны бүлгээс бусад бүх насны бүлэг бүрт эмэгтэйчүүдийн тоо өндөр байгаа хандлага ажиглагдаж байна. Шилжин ирэгсдийн насны бүтцийг авч үзвэл ерөнхийдөө 15-24 насанд төвлөрсөн (43.7 хувь) бөгөөд нас ахихын хэрээр шилжих хөдөлгөөнд оролцох нь багассан байна.

Шилжин ирэгсдийн дотор зах зээлд ойртох (37.1 хувь), ажиллах (33.6 хувь), суралцах (32.5 хувь) зэрэг нь шалтгааны улмаас шилжигсэд өндөр хувийг эзэлж байлаа.



**Эх сурвалж:** ХАССТ, Монгол Улсын хүн амын дотоод шилжих хөдөлгөөнийн микро түвшний судалгаа 2000.

Үүний дараагаар амьдралын нөхцлөө сайжруулах, хүүхдүүдийнхээ ирээдүйг бодох, төрөл саднаа бараадах зэрэг шалтгаанууд орж байна. Улаанбаатар хотод шилжин суурьшсан нийт хүн амын 592 нь буюу 66.9 хувь нь шилжин ирснээсээ хойш ямар нэгэн ажил эрхэлсэн бөгөөд эдгээр хүн амын 558 нь буюу 94.2 хувь нь одоогийн байдлаар ажил эрхэлж байна. Ажил эрхэлж байгаа хүн амын нас, хүйсийн бүтцийг үзвэл 45-49 наснаас бусад бүх насанд эмэгтэй хүн амын ажил эрхлэлт өндөр байгаа бөгөөд энэ нь эмэгтэй шилжигсдийн хувийн жин өндөр байгаатай холбоотой. (Зураг 5) Ажил эрхлэлтийг хүйсээр ялган авч үзэхэд төдийлөн ялгаа багатай байна. (Эрэгтэй ба эмэгтэй хүн амын хүн амын ажил эрхлэлт харгалзан 66.1, 67.5 хувь) Эрэгтэй хүн амын хувьд 20-24 нас, эмэгтэй хүн амын хувьд 15-19 нас нь ажил эрхлэлтийн хамгийн идэвхтэй үе байна.

Ажил эрхэлж байгаа 10 хүн тутмын 7 нь бүрэн дундаас дээш боловсролтой буюу ямар нэгэн мэргэжил эзэмшсэн хүмүүс байгаагаас ажил эрхлэлтэнд боловсролын түвшин шууд нөлөөтэй гэж хүчин зүйл гэдгийг хэлж болохоор байна.

Улаанбаатар хотод шилжин ирэгсдийн 51.5 хувь нь нэг сар хүртэлх, 34.8 хувь нь нэг жил хүртлэх, үлдсэн нь нэг жилээс дээш хугацаанд хүлээсний эцэст ажилд орсон ба ажил эрхэлж байгаа хүмүүсийн хувьд ажилд орсон дундаж хугацаа нь 105.76 өдөр буюу 3 сар, 15 хоног байна. Энэ үзүүлэлт хүйсийн хувьд ялгаа багатай буюу эрэгтэй хүн амын хувь 3 сар 9 хоног, эмэгтэй хүн амын хувьд 3 сар 21 хоног байна.

**Хүснэгт 2. Хүн амын хувь, ажил эрхлэлтийн байдал, хүйсээр**

Ажил эрхлэлтийн байдал	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд
Төрийн/төсвийн байгууллага	8.6	9.8	9.3
Төрийн өмчийн ААН, байгууллага	3.4	1.6	2.4
Хувийн ААН, байгууллага	17.2	13.3	15.0
Төрийн бус байгууллага	1.1	0.4	0.7
Хувираа ажил, наймаа хийдэг	14.9	7.6	10.8
Сурдаг	15.4	26.1	21.5
Гэрийн ажилтай	1.0	4.0	2.7
Малчин	1.3	0.4	0.8
Ажил эрхлээгүй	37.1	36.8	36.9
Бүгд	66,1	67,5	66.9
Тоо	383	502	885

**Эх сурвалж:** ХАССТ, Монгол Улсын хүн амын дотоод шилжих хөдөлгөөний микро түвшний судалгаа 2000

Улаанбаатарт шилжин ирсэн 5 хүн тутмын нэг нь (21.5 хувь) суралцаж байгаа нь шилжих хөдөлгөөнд 15-24 насныхны ихээр оролцсонтой холбоотой. Түүнчлэн суралцах нь шилжихэд хүргэж буй нэг томоохон шалтгаан билээ. Харин гурав дахь шатны сургуульд суралцагсдын хүйсийн ялгаа нэлээд өндөр байгаа нь ажиглагдаж байна. Хувийн ААН, байгууллага дахь ажил эрхлэлт нь төрийн/төсвийн байгууллага дахь ажил эрхлэлтээс 5.7, төрийн өмчийн ААН/байгууллага дахь ажил эрхлэлтээс 12.6 пунктээр өндөр үзүүлэлт байна. Энэ нь нэг талаас ихэнх үйлдвэр, ААН-үүд хувьчлагдаж, шинээр хувийн ААН, байгууллагууд нэмэгдэж байгаатай, нөгөөтэйгүүр хувийн ААН-д ажилд ороход харьцангуй хялбар байдагтай холбоотой болов уу. Мөн ажил эрхэлж байгаа хүмүүсийн дийлэнх нь ногдож буй хоёрдогч ба гуравдагч салбарууд ихэвчлэн хувийн байгууллагууд байна. (ҮСГ, 2000)

Ажил эрхлэлтийн байдлыг хүйсээр авч үзэхэд, хувиараа ажил, наймаа хийдэг эрэгтэйчүүдийн хувь эмэгтэй хүн амаас бараг хоёр дахин өндөр байгаа нь зах дээр худалдаа эрхлэгчид, валютын ченжүүд, таксины жолоочид зэрэг ихэвчлэн албан бус секторт ажил эрхэлж буй эрэгтэй хүн амын хувь эмэгтэйчүүдээс өндөр байгаагаар тайлбарлагдана. Харин гэрийн ажилтай эмэгтэйчүүдийн хувь эрэгтэйчүүдийнхээс даруй 4 дахин өндөр байгаа нь хүүхэд, өвчтөн, өндөр настан асрах зэрэг үнэлгээгүй ажилд эмэгтэй хүн ам түлхүү оролцдог хандлага Улаанбаатар хотын хувьд ч адилхан байгааг харуулж байна.

Ажил эрхлэлтийн тогтвортой байдлыг авч үзэхэд шилжин ирсэн эрэгтэй хүн амын 14.6 хувь, эмэгтэй хүн амын 12.4 хувь нь анх ажиллаж байсан ажлын байраа сольсон байна. Эрхэлдэг ажлаа сольсон хүмүүсийн ихэнх нь буюу 65.8 хувь нь 15-34 насныхан, 88.6 хувь нь бүрэн дундаас дээш боловсролтой хүмүүс байжээ. Үүнээс боловсролын түвшин

өндөртэй хүмүүс хүссэн ажлын байрандаа сонголт хийж ажиллах боломж боловсрол багатай хүмүүсийг бодвол харьцангуй өндөр байдаг гэж хэлж болохоор байна. Ажлын байраа сольсон 2 хүн тутмын нэг нь хувийн байгууллагад ажиллаж байсан бол ердөө 5 хувь нь төрийн өмчийн ААН, байгууллагад ажиллаж байжээ. Энэ нь төрийн/төсвийн болон төрийн өмчийн ААН/байгууллагуудтай харьцуулахад хувийн байгууллагуудын ажлын нөхцөл муу, цалингийн түвшин доогуур байдалтай холбоотой байна. Нөгөө талаар хувийн байгууллагуудад ажилд орсон тохиолдолд ажил олгогч, ажилчин хоёрын хооронд хөдөлмөрийн гэрээ тэр болгон байгуулдаггүйтэй ч холбон тайлбарлаж болно.

Шилжин ирээд ажил эрхлэхгүй байгаа нийт хүн амд ажил хайгаад олдохгүй байгаа гэдэг шалтгаанаар ажил эрхлэхгүй байгаа хувь өндөр байна. (41 хувь) Үүнээс шилжин ирэгсэд ажил эрхлэх сонирхолтой, эдийн засгийн идэвхтэй хүмүүс байна гэж хэлж болох юм. Үүний дараагаар ажил хийх шаардлагагүй гэсэн шалтгаан (20 орчим хувь) орж байгаа ба ийм хариулт өгсөн хүмүүсийн хувь бараг тэн хагас нь ядуу бус дундаас дээш орлоготой хүмүүс байна. Шилжин ирсэн хүн амын дунд тахир дутуугийн группт, мэдлэг хүрэхгүй, тохирох ажил олдохгүй зэрэг шалтгаанаар ажил эрхлэхгүй байгаа хүн амын хувийн жин хамгийн бага буюу 1.5-3.4 хувь байгаа нь хамгийн их дурьдагдсан шалтгаанаас даруй 37.6-39.5 пунктээр бага үзүүлэлт байна.

Улаанбаатар хотод шилжин ирээд ажил эрхэлж байгаа нийт хүн амын 1/3-с илүү нь шилжих шийдвэрээ гаргахдаа ажил эрхлэх зорилгыг агуулсан бөгөөд, ажил эрхлэх зорилготойгоор шилжин ирэгсдийн 77.6 хувь нь одоогийн байдлаар ямар нэгэн ажил эрхэлж байна.

### Шилжигчдийн ахуй амьдралд ажил эрхлэлт нөлөөлөх нь

Хүснэгт 3. Хүн амын хувь, ажил эрхлэлтийн байдал, шилжин ирсний дараа амьдралын нөхцөл байдалд гарсан өөрчлөлтөөр

Хэмжүүрүүд	Үзүүлэлтүүд											
	Ажил эрхлэлтийн байдал		Орлого		Боловсрол, мэргэжлийн чадвар		Орон сууцны нөхцөл байдал		Эрүүл мэнд		Зах зээл, худалдан авах, худалдаалах боломж	
	Ажил эрхэлж байгаа	Ажил эрхлээгүй	Ажил эрхэлж байгаа	Ажил эрхлээгүй	Ажил эрхэлж байгаа	Ажил эрхлээгүй	Ажил эрхэлж байгаа	Ажил эрхлээгүй	Ажил эрхэлж байгаа	Ажил эрхлээгүй	Ажил эрхэлж байгаа	Ажил эрхлээгүй
Сайжирсан	57,7	11,9	51,8	20,5	51,8	16	31,7	19,8	15,6	16	84,8	75,1
Хэвээрээ	28,1	45,7	31	46,4	45,2	72,4	50	60,8	80,1	75,1	10,9	18,8
Доройтсон	3,8	27,3	3,6	22,9	1,4	9,1	16,3	15,4	3,6	8,2	3,6	4,4
Мэдэхгүй	9,5	13	12	9,2	1,3	2,5	1,8	3,0	0,2	0,7	0,7	1,0
Хамааралгүй	0,9	2,1	1,6	1,0	0,3		0,2	1,0	0,5			0,7
Бүгд	100	100	100	100	100	100	100	100	100	100	100	100
Тоо	558	327	558	327	558	327	558	327	558	327	558	327

**Эх сурвалж:** ХАССТ, Монгол Улсын хүн амын дотоод шилжих хөдөлгөөний микро түвшний судалгаа 2000

Улаанбаатар хотод шилжин ирэгсдийн тэн хагасаас илүү нь ажлын нөхцөл болон цалин хөлсний хувьд өмнөхөөсөө илүү сайн ажил эрхэлж байгаа нь маш “эерэг” үзүүлэлт юм. Иймээс ч ажил эрхлээгүй хүмүүстэй харьцуулахад, ажил эрхэлж байгаа хүн амын хувьд ахуй, амьдралд нь дэвшил, дээшлэлт гарсан үзүүлэлт олон байна. Харин ажил эрхлээгүй хүн амын хувьд амьдрал, ахуйд нь гарсан өөрчлөлтүүдийг тодорхойлогч үзүүлэлтүүдийн ихэнхэд онцын өөрчлөлт гараагүй буюу доройтсон хандлага ажиглагдлаа. Үүнээс хүн амын ажил эрхлэлт нь амьжиргааны түвшинд нөлөөлөгч гол үзүүлэлт гэж хэлж болох бөгөөд хүмүүс ажилгүй байснаар наад захын идэж уух, өмсөж хэрэглэх хэрэгцээгээр дутагдаад зогсохгүй, бие бялдар, оюун санааны хувьд хоцрогдож, улмаар хотын хүн амын дунд ядуурал, тэгш бус эмзэг байдал нэмэгдэх, нийгмийн сөрөг үзэгдлүүд газар авахын үндэс болно.

### **Улаанбаатар хотод шилжин ирсэн хүн амын ажил эрхлэлтэнд нөлөөлөгч хоёр хүчин зүйлийн (хамаарлын) шинжилгээ**

Улаанбаатар хотод шилжин ирсэн хүмүүсийн хувьд ажил эрхлэлтэнд нөлөөлөгч гэж үзэж буй хүчин зүйлүүд нь ажил эрхлэлтийн байдал буюу бидний авч үзэж байгаагаар таамаглагдаж буй хүчин зүйлтэй ямар хамааралтай байна вэ, цаашид олон хүчин зүйлийн шинжилгээнд тухайн хувьсагчийг авах нь хэр бодитой вэ гэсэн асуултанд хариулт өгөх зорилгоор хоёр хүчин зүйлийн хамаарлын шинжилгээг хийсэн болно.

1. *Дэвшүүлж буй буюу тэг таамаглал  $H_0$* : Хүн ам зүйн хүчин зүйлүүд болох шилжигчийн нас, боловсролын түвшин, өрхийн ам бүлийн тоо, нийгэм, эдийн засгийн хүчин зүйлүүд болох Улаанбаатарт шилжин ирэхээс өмнөх байршил, шилжилтийн шалтгаан, өрхийн сарын хэрэглээний нэг хүнд ногдох түвшин гэсэн үзүүлэлтүүд нь ажил эрхлэлтийн байдалд нөлөөлнө, өөрөөр хэлбэл эдгээр хувьсагчдын хооронд статистик хамаарал оршино.
2. *Өрсөлдөгч таамаглал  $H_1$* : Дээрх хүн ам зүйн болон нийгэм, эдийн засгийн хүчин зүйлүүд нь ажил эрхлэлтийн байдалтай хамааралгүй.
3. *Статистик шалгуур*: Ажил эрхлэлт ба түүнд нөлөөлнө гэж авч үзэж байгаа хувьсагчуудын хоорондын хамаарлыг хамгийн их үнэний хувь бүхий аргад үндэслэх  $\chi^2$ - шалгуураар үнэлэв. Хамаарлын эрч хүчийг Крамерийн  $V$  нэрлэсэн хэмжигдэхүүнээр тодорхойлно.
4. *Итгэх түвшин-г  $\alpha = 0.05$*  буюу үнэлгээний алдааг хамгийн ихдээ 95% байхаар тооцсон.
5. *Түүвэр олонлогийн тархалт-ыг  $(r-1)(c-1)$*  гэсэн чөлөөний зэрэг бүхий  $\chi^2$  тархалтаар тархана гэж үзнэ.
6. *Шалгуур муж-ийг чөлөөний зэрэг (df)* болон итгэх түвшинг ашиглан үнэлсэн утгаа хүснэгтийн онолын утгатай харьцуулан үнэлсэн.

## Хүн ам зүйн хүчин зүйлс ба ажил эрхлэлтийн хамаарал

Хүснэгт 4. Хүн ам зүйн хүчин зүйлс ба ажил эрхлэлтийн хоорондын хамаарал, хүйсээр

Хүн ам зүйн хүчин зүйл	Ажил эрхэлдэг хүн ам	
	Эрэгтэй	Эмэгтэй
Нас		
$\chi^2$	22,855	66,368
<i>Df</i>	2	2
<i>Cramer's V</i>	0,744	0,614
Боловсролын түвшин		
$\chi^2$	19,108	29,879
<i>Df</i>	2	2
<i>Cramer's V</i>	0,854	0,917
Өрхийн ам бүлийн тоо		
$\chi^2$	15,209	9,558
<i>Df</i>	3	3
<i>Cramer's V</i>	0,456	0,377

**Тайлбар:**  $V \rightarrow 1$  Хоёр хувьсагчийн хүчтэй хамаарлыг,  $V \rightarrow 0$  сулавтар хамаарлыг,  $V < 0$  хамааралгүй болохыг харуулна. Бүх хувьсагчуудийн хувьд таамаглагдаж байгаа болон барагцаалсан ач холбогдлын түвшин нь  $P=0.000$  гэж тодорхойлогдсон.

Хүн ам зүйн хүчин зүйлүүд нь ажил эрхлэлтийн байдалтай статистикийн өндөр ач холбогдол бүхий хамааралтай байна. Иймээс хүн ам зүйн хүчин зүйлүүд болон ажил эрхлэлтийн байдал нь хамааралгүй гэсэн  $H_1$  таамаглалыг няцаах үндэслэлтэй гэдгийг дээрх хүснэгтийн үр дүн харуулж байна. Тухайн шилжигчийн нас нь ажил эрхлэлтийн байдалтай хүчтэй, боловсролын түвшин нь маш хүчтэй, өрхийн ам бүлийн тоо нь дунд зэрэг хамааралтай байна.

## Нийгэм эдийн засгийн хүчин зүйлс ба ажил эрхлэлтийн хамаарал

Хүснэгт 5. Нийгэм, эдийн засгийн хүчин зүйлс ба ажил эрхлэлтийн хоорондын хамаарал, хүйсээр

Нийгэм, эдийн засгийн зүйн хүчин зүйл	Ажил эрхэлдэг хүн ам	
	Эрэгтэй	Эмэгтэй
Шилжин ирэхээс өмнөх байршил		
$\chi^2$	16,051	15,029
<i>Df</i>	5	5
<i>Cramer's V</i>	0,86	0,95
Шилжилтийн шалтгаан		
$\chi^2$	14,449	9,519
<i>Df</i>	1	1
<i>Cramer's V</i>	0,794	0,718
Орон сууцны нөхцөл		
$\chi^2$	11,855	5,921
<i>Df</i>	2	2
<i>Cramer's V</i>	0,121	0,157
Өрхийн нэг хүнд ногдох сарын хэрэглээний түвшин		
$\chi^2$	21,655	22,921
<i>Df</i>	4	4
<i>Cramer's V</i>	0,576	0,666
Бүртгэлийн статус		

$\chi^2$	1,247	2,541
Df	1	1
Cramer's V	0,056	0,091

**Тайлбар:**  $V \rightarrow 1$  Хоёр хувьсагчийн хүчтэй хамаарлыг,  $V \rightarrow 0$  Хоёр хувьсагчийн сулавтар хамаарлыг харуулна. Өрхийн орон сууцны нөхцөл, бүртгэл гэсэн хувьсагчуудаас (0.122 ба 0.325) бусад хувьсагчуудийн хувьд таамаглагдаж байгаа болон барагцаалсан ач холбогдлын түвшин нь  $P=0.000$  гэж тодорхойлогдсон.

Нийгэм, эдийн засгийн хүчин зүйлүүд ба ажил эрхлэлтийн хооронд тодорхой хамаарал оршиж байгаа бөгөөд шилжилтийн шалтгаан ба шилжин ирэхээс өмнөх байршил зэрэг нь ажил эрхлэлтэнд маш хүчтэй нөлөө үзүүлж байна. Ялангуяа шилжин ирэхээс өмнөх байршил болон эмэгтэй хүн амын ажил эрхлэлт хоорондоо бараг төгс гэж хэлж болохоор хамааралтай байна. Шилжигчийн орон сууцны нөхцөл, бүртгэл зэрэг нь ажил эрхлэлтийн байдалтай бараг хамааралгүй, эдгээр үзүүлэлтүүдийн хооронд статистик ач холбогдол оршихгүй байгаа учраас олон хүчин зүйлийн шинжилгээнд оруулаагүй.

### **Улаанбаатар хотод шилжин ирсэн хүн амын ажил эрхлэлтэнд нөлөөлөгч олон хүчин зүйлийн шинжилгээ**

Өмнө авч үзсэн хүн ам зүйн болон нийгэм, эдийн засгийн хүчин зүйлүүд нь ажил эрхлэлтийн байдалтай хамааралтай нь тогтоогдсон билээ. Тэгвэл эдгээр хувьсагчуудын хамаарлын зүй тогтол чухам ямар хуулиар явагдаж байна вэ, өөрөөр хэлбэл ажил эрхлэлтийн байдалд хүн ам зүйн болон нийгэм, эдийн засгийн хүчин зүйлс хэрхэн нөлөөлж байна гэдгийг ложистик регрессийн тэгшитгэлээр үнэлэв.

#### **Хүснэгт 6. Эрэгтэй хүн амын ажил эрхлэлтэнд нөлөөлөгч зүйлийн ложистик регрессийн үр дүн, сонгосон үл хамаарах хувьсагчуудаар**

Үл хамаарах хувьсагчид	Логарифм/Магадлалын харьцаа	
	Загвар А	Загвар В
<b>1. ХҮН АМ ЗҮЙН ХҮЧИН ЗҮЙЛС</b>		
Нас		
15-24	1.000	1.000
25-44	1.075***	2.822***
45+	0.183**	0.922**
Боловсролын түвшин		
Бүрэн дундаас дээш	1.92**	2.01***
Бүрэн дунд ба түүнээс доош	0.299	1.71*
Боловсролгүй	1.000	1.000
Өрхийн ам бүлийн тоо		
1	1.000	1.000
2-5	0.299	0.224
6-9	1.238**	2.482*
10+	0.561	0.496
<b>2. НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ХҮЧИН ЗҮЙЛС</b>		
Шилжин ирэхээс өмнөх байршил		
Нийслэл		0.265
Аймгийн төв		10.202*
Тосгон		20.638
Сумын төв		21.415
Хөдөө		1.000
Гадаад		
Шилжилтийн шалтгаан		
Ажиллах		5.125**

Бусад		1.000
Сарын хэрэглээний түвшин		
Нэн ядуу		1.112
Ядуу		1.151
Бага орлоготой		1.000
Дундаж орлоготой		2.001
Өндөр орлоготой		0.954
$\chi^2$	434.564	437.888
$R^2$	0.589	0.713

**Тайлбар:**  $P < 0.05$  түвшинд ач холбогдлын коэффициентийг тооцов.  $0.05 > P > 0.01$  Хоёр хувьсагчийн сул хамаарлыг (\*),  $0.01 > P > 0.0001$  Дунд зэрэг хамаарлыг (\*\*),  $P < 0.0001$  Хүчтэй хамаарлыг (\*\*\*)

**ЗАГВАР А:** Хүн ам зүйн хүчин зүйлс ба шилжигч эрэгтэйчүүдийн ажил эрхлэлтийн хамаарлыг харуулсан загвар

**ЗАГВАР В:** Хүн ам зүй, нийгэм эдийн засгийн хүчин зүйлс ба шилжигч эрэгтэйчүүдийн ажил эрхлэлтийг харуулсан загвар

ЗАГВАР А-ийн хувьд хүн ам зүйн хүчин зүйлүүд нь статистикийн ач холбогдол бүхий хамааралтай байна. Ажил эрхлэлтийн хамгийн идэвхтэй гэж хэлж болох 25-44 насны эрэгтэйчүүдийн ажил эрхлэх магадлал 15-24 насны эрэгтэй хүн амын ажил эрхлэх магадлалаас 1.08 дахин өндөр, харин ахимаг насны хүн амын ажил эрхлэх магадлал 15-24 насныхны ажил эрхлэх магадлалаас бага байна. ( $P = 0.000$ )

Огт боловсролгүй эрэгтэйчүүдийг бодвол бүрэн дундаас дээш боловсролтой эрэгтэйчүүдийн ажил эрхлэх магадлал 2 дахин ( $P = 0.009$ ) өндөр байгаа нь ажил эрхлэлт ба боловсролын түвшний хоорондын эерэг хамаарлыг харуулж байна.

Ганцаараа шилжин ирсэн эрэгтэйчүүдийг бодвол, 6-9 ам бүлтэй өрхийн гишүүдийн ажил эрхлэлт 1.2 дахин өндөр байна. Энэ нь ганцаараа шилжин ирэгсдийн гол шалтгаан нь суралцах явдал байгаатай холбоотой бөгөөд, гэр бүлээрээ шилжин ирсэн өрхийн гишүүд амьжиргаагаа дээшлүүлэхийн тулд ямар нэгэн байдлаар ажил эрхэлдэг гэж хэлж болохоор байна.

А загварыг өргөтгөөд, хавсарсан нөлөөллөөр дахин үнэлснээр ач холбогдолтой үзүүлэлтүүд хэвээр хадгалагдаж, үнэний хувийн харьцаа өссөн ( $\chi^2$ ) бөгөөд, загварын бодитой байдал нэмэгдсэн хандлага ажиглагджээ. (Загвар В) Сонгож авсан хүн ам зүйн үзүүлэлтүүдийн шилжигч эрэгтэйчүүдийн ажил эрхлэлтийн байдлыг тайлбарлах чадвараас хүн ам зүйн болон нийгэм, эдийн засгийн үзүүлэлтүүдийн нь шилжигч эрэгтэй хүн амын ажил эрхлэлтийг тайлбарлах чадвар нь сайн байна. Дээрх хүн ам зүйн болон нийгэм, эдийн засгийн үзүүлэлтүүд ба шилжигч эрэгтэй хүн амын ажил эрхлэлтийн хооронд 0.713 буюу хүчтэй гэж хэлж болохоор хамаарал оршиж байгаа бөгөөд, шилжигч эрэгтэйчүүдийн ажил эрхлэлтийн байдал дахь дээрх үзүүлэлтүүдийн нөлөөлөл 71.3 хувь, бусад үзүүлэлтүүдийн нөлөөлөл 28.7 хувь байна.

Хөдөөнөөс шилжин ирсэн эрэгтэй хүн амтай харьцуулахад аймгийн төвөөс Улаанбаатарт шилжин ирсэн эрэгтэй хүмүүсийн ажил эрхлэх магадлал нь 10 дахин өндөр ( $P = 0.040$ ) байгаа нь хөдөөнөөс шилжин ирэгсэд ихэвчлэн малчид буюу мэргэжил боловсролгүй, ажлын дадлага муутай хүмүүс байдагтай холбоотой юм. Ажил эрхлэх зорилгоор шилжин ирсэн эрэгтэйчүүдийн хувьд ажил эрхлэх магадлал нь бусад зорилгоор шилжин ирсэн эрэгтэй хүн амынхаас 5 дахин өндөр байна. ( $P = 0.289$ )

Үүнээс, Улаанбаатар хотод шилжин ирэгсэд маань зорилгоо тодорхой хэмжээгээр биелүүлж байна гэж дүгнэж болохоор байна.

Харин тухайн өрхийн амьжиргааны үзүүлэлт нь эрэгтэй шилжигчийн хувьд ажил эрхлэлтийн байдалтай хамааралгүй гарчээ. Ложистик регрессийн загварын тэгшитгэлийг логарифмын харьцааг ашиглан шугаман регрест шилжүүлэх ба тэгшитгэлийг гаргаснаар хүн ам зүйн болон нийгэм, эдийн засгийн хүчин зүйлсийн эрэгтэй хүн амын ажил эрхлэлтэн дэх нөлөөллийн зүй тогтлыг харж болно.

Улаанбаатарт шилжин ирсэн эрэгтэй хүн амын ажил эрхлэлт ба хүн ам зүй, нийгэм эдийн засгийн үзүүлэлтүүдийн хамаарлын тэгшитгэл. Үүнд:

- Y- Ажил эрхлэлт
- X<sub>1</sub>- Нас
- X<sub>2</sub>- Гэр бүлийн хэмжээ
- X<sub>3</sub>- Боловсролын түвшин
- X<sub>4</sub>- Шилжин ирэхээс өмнөх байршил
- X<sub>5</sub>- Шилжилтийн шалтгаан
- X<sub>6</sub>- Сарын хэрэглээний түвшин

$$Y = -4.590 + \begin{pmatrix} 0.281 \\ 1.458 \end{pmatrix} x_1 + \begin{pmatrix} -2.076 \\ -1.128 \\ -1.399 \end{pmatrix} x_2 + \begin{pmatrix} 5.278 \\ 4.712 \end{pmatrix} x_3 + \begin{pmatrix} 1.526 \\ 0.194 \\ 0.538 \\ 0.251 \\ 0.368 \end{pmatrix} x_4 + \begin{pmatrix} 0.815 \\ 1.254 \end{pmatrix} x_5 + \begin{pmatrix} -0.141 \\ -0.045 \\ -0.254 \\ -0.273 \end{pmatrix} x_6;$$

-4.590 нь хамаарах хувьсагчийн босоо тэнхлэгтэй огтлолцох утга юм. Тэгшитгэлээс харахад, эрэгтэй хүн амын ажил эрхлэлтийн байдал нь шилжигчийн настай эерэг, өрхийн ам бүлийн тоотой сөрөг, боловсролын түвшинтэй эерэг, шилжилтийн шалтгаантай эерэг, сарын хэрэглээний түвшинтэй сөрөг хамааралтай байна. Шилжигчдийн наснаас бусад бүх үзүүлэлтүүд тогтмол байхад, нас нь ажил эрхлэлтийн байдалд 1.739 нэгжээр нөлөөлнө. Хамгийн хүчтэй, эерэг нөлөө үзүүлж буй хүчин зүйл нь шилжигчдийн боловсрол, хамгийн бага нөлөөтэй нь шилжигчийн сарын хэрэглээний түвшин байна. Харин гэр бүлийн хэмжээ нь хамгийн хүчтэй сөрөг нөлөөг үзүүлж байна. Өөрөөр хэлбэл тухайн өрхийн ам бүлийн тоо өсөх буюу гэр бүлийн хэмжээ нэмэгдэхэд ажил эрхлэлт нь буурдаг гэсэн зүй тогтол ажиглагдаж байна.

**Хүснэгт 7. Эмэгтэй хүн амын ажил эрхлэлтэнд нөлөөлөгч зүйлийн ложистик регрессийн үр дүн, сонгосон үл хамаарах хувьсагчуудаар**

Үл хамаарах хувьсагчид	Логарифм/Магадлалын харьцаа	
	Загвар А1	Загвар В1
<b>1. ХҮН АМ ЗҮЙН ХҮЧИН ЗҮЙЛС</b>		
<i>Нас</i>		
15-24	1.000	1.000
25-44	2.320**	1.325*
45+	9.810	4.296
<i>Боловсролын түвшин</i>		
Бүрэн дундаас дээш	1.001*	8.945***
Бүрэн дунд ба түүнээс доош	0.04	4.215
Боловсролгүй	1.000	1.000



Өрхийн ам бүлийн тоо		
1	1.000	1.000
2-5	0.220	0.105
6-9	0.544	0.324
10+	0.561	0.247
2. НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ХҮЧИН ЗҮЙЛС		
Шилжин ирэхээс өмнөх байршил		
Нийслэл		1.000
Аймгийн төв		4.602**
Тосгон		0.823
Сумын төв		0.584*
Хөдөө		1.244
Гадаад		1.445
Шилжилтийн шалтгаан		
Ажиллах		2.444***
Бусад		1.000
Сарын хэрэглээний түвшин		
Нэн ядуу		1.754
Ядуу		0.478
Бага орлоготой		1.000
Дунд орлоготой		1.521
Өндөр орлоготой		0.689*
$\chi^2$	551.280	558.236
$R^2$	0.518	0.781

**Тайлбар:**  $P < 0.05$  түвшинд ач холбогдлын коэффициентийг тооцов.  $0.05 > P > 0.01$  Хоёр хувьсагчийн сул хамаарлыг (\*),  $0.01 > P > 0.0001$  Дунд зэрэг хамаарлыг (\*\*),  $P < 0.0001$  Хүчтэй хамаарлыг (\*\*\*)

**ЗАГВАР А1:** Хүн ам зүйн хүчин зүйлс ба шилжигч эмэгтэйчүүдийн ажил эрхлэлтийн хамаарлыг харуулсан загвар

**ЗАГВАР В1:** Хүн ам зүй, нийгэм, эдийн засгийн хүчин зүйлс ба шилжигч эмэгтэйчүүдийн ажил эрхлэлтийг харуулсан загвар

Улаанбаатарт шилжин ирсэн эмэгтэй хүн амын хувьд тодорхойлсон хүн ам зүйн хүчин зүйлс, хүн ам зүйн ба нийгэм, эдийн засгийн хүчин зүйлсийн ажил эрхлэлтэн дэх нөлөөллийг харуулсан загвар нь эрэгтэй хүн амын хувьд тодорхойлогдсон загвартай адилхан хандлагатай гарсан байна.

Загвар А1-ийн хувьд шилжигч эмэгтэйчүүдийн нас, боловсролын түвшин нь ажил эрхлэлтийн байдалтай статистик хамааралтай гарч, харин өрхийн ам бүлийн тоо төдийлөн нөлөөлөлгүй байна.

Загвар В1-ийн хувьд үнэний хувийн харьцаа өсөж, энэхүү загварт багтсан үзүүлэлтүүдийн шилжигч эмэгтэй хүн амын ажил эрхлэлтийг тайлбарлах чадвар нэмэгджээ. Өөрөөр хэлбэл, дан хүн ам зүйн үзүүлэлтүүдээс хүн ам зүй, нийгэм, эдийн засгийн үзүүлэлтүүд нь ажил эрхлэлтийн байдалд хүчтэй нөлөөлж байгаа төдийгүй эдгээр үзүүлэлтүүдийн хамаарах хувьсагч дахь нөлөөлөл нь 78.1 хувь байна. Харин 21.9 хувь нь загварт багтаагүй бусад үзүүлэлтүүдийн нөлөөлөл байгаа ажээ.

Огт боловсролгүй эмэгтэйчүүдийг бодвол бүрэн дундаас дээш боловсрол эзэмшсэн эмэгтэйчүүдийн ажил эрхлэлт 8.9 дахин өндөр ( $P = 0.025$ ) байгаа нь эрэгтэй хүн амтай харьцуулахад 4 дахин өндөр үзүүлэлт байна. Энэ нь боловсролгүй ч гэсэн ажил эрхлэх боломж эмэгтэйчүүдтэй харьцуулахад эрэгтэйчүүдийн хувьд өндөр байгаа гэсэн үг юм.

Шилжин ирэхээс өмнөх байршлын хувьд хөдөөнөөс шилжин ирсэн эмэгтэйчүүдтэй харьцуулахад аймгийн төвөөс шилжин ирэгсдийн хувьд

ажил эрхлэлт нь бараг 4 дахин өндөр ( $P=0.003$ ) байхад, сумын төвөөс шилжин ирэгсдийн ажил эрхлэх магадлал ялимгүй бага байна. ( $P=0.042$ )

Ажил эрхлэх зорилгоор шилжин ирсэн эмэгтэйчүүдийн ажил эрхлэх магадлал бусад шалтгаанаар шилжих хөдөлгөөнд оролцсон эмэгтэйчүүдийн ажил эрхлэх магадлалаас 2 дахин өндөр байна. Хэрэглээний түвшин эрэгтэй хүн амтай харьцуулахад нь эмэгтэй хүн амын ажил эрхлэлтэнд илүүтэй нөлөө үзүүлж байна. Сарын хэрэглээний зардлын түвшин нь харьцангуй доогуур буюу бага орлоготой эмэгтэйчүүдийг бодвол өндөр орлоготой эмэгтэйчүүдийн ажил эрхлэх магадлал 0.7 дахин бага байгаагаас ( $P=0.049$ ) амьжиргааны түвшин өндөртэй өрхийн эмэгтэй гишүүдийн хувьд ажил эрхлэлт доогуур байж болох юм гэж хэлж болохоор байна.

Улаанбаатарт шилжин ирсэн эмэгтэй хүн амын ажил эрхлэлт ба хүн ам зүй, нийгэм эдийн засгийн үзүүлэлтүүдийн хамаарлын тэгшитгэлийг доорх байдлаар илэрхийлж байна.

$$Y = -5.987 + \begin{pmatrix} 1.037 \\ 2.232 \end{pmatrix} X_1 + \begin{pmatrix} -1.494 \\ -0.729 \\ -0.702 \end{pmatrix} X_2 + \begin{pmatrix} 6.573 \\ 7.468 \end{pmatrix} X_3 + \begin{pmatrix} -0.530 \\ 5.289 \\ 5.311 \\ 5.359 \\ 5.042 \end{pmatrix} X_4 + \begin{pmatrix} 6.964 \\ 7.607 \end{pmatrix} X_5 + \begin{pmatrix} -0.738 \\ -0.301 \\ -0.380 \\ -0.253 \end{pmatrix} X_6;$$

Эмэгтэй хүн амын ажил эрхлэлтэнд хамгийн хүчтэй нөлөөг байршил, хамгийн бага нөлөөг нас үзүүлж байхад, хамгийн хүчтэй сөрөг нөлөөг шилжигчийн сарын хэрэглээний түвшин үзүүлж байна. Өрхийн ам бүлийн тоо нэгжээр өөрчлөгдөхөд эмэгтэй хүн амын ажил эрхлэлт 2.925 нэгжээр буурна. Эсрэгээр шилжигч эмэгтэйчүүдийн боловсролын түвшин нэгжээр өсөхөд тэдний ажил эрхлэлт нь 14.041 нэгжээр өснө.

## Дүгнэлт

Улаанбаатар хотод шилжин суурьшсан 10 хүн тутмын 6-7 нь шилжин ирснээсээ хойш ямар нэгэн ажил эрхэлсэн бөгөөд эдгээр хүн амын 94.2 хувь нь одоогийн байдлаар ажил эрхэлж байна. Ажил эрхэлж байгаа хүн амын дотор хувийн ААН/байгууллагад ажиллагсад болон хувиараа ажил/наймаа хийж байгаа хүмүүсийн хувийн жин харьцангуй өндөр байна.

Улаанбаатар хотод шилжин ирэгсдийн тэн хагасаас илүү нь ажлын нөхцөл болон цалин хөлсний хувьд өмнөхөөсөө илүү сайн ажил эрхэлж байгаа ба тэдний хувьд орлого, худалдан авах худалдаалах боломж, орон сууцны нөхцөл, эрүүл мэнд зэрэг үзүүлэлтүүдэд нэлээд ахиц гарсан эерэг үр дүн харагдаж байна.

Шилжин ирсэн хүн амын ажил эрхлэлтийн байдалд нөлөөлнө гэж таамагласан хүчин зүйлүүд болох шилжигчийн нас, боловсролын түвшин, өрхийн ам бүлийн тоо, шилжин ирэхээс өмнөх байршил, шилжилтийн шалтгаан, сарын хэрэглээний түвшин зэрэг хувьсагчид бүгд ажил эрхлэлтийн байдалтай статистикийн ач холбогдол бүхий хамааралтай, хамаарлын хүч нь харилцан адилгүй байна. Эдгээр үзүүлэлтүүдийн эрэгтэй хүн амын ажил эрхлэлтийг тайлбарлах чадвар 71 хувь, эмэгтэй хүн амын ажил эрхлэлтийг тайлбарлах чадвар 78 хувь байна.

Шилжигч эрэгтэй хүн амын ажил эрхлэлтэнд хамгийн хүчтэй эерэг нөлөөтэй хүчин зүйл нь боловсролын түвшин байхад, сарын хэрэглээний түвшин төдийлөн нөлөөтэй үзүүлэлт биш байв. Ерөнхийдөө 25-44 насны, бүрэн дундаас дээш боловсролтой, аймгийн төвөөс, ажиллах зорилгоор шилжин ирсэн эрэгтэйчүүдийн ажил эрхлэх магадлал хамгийн өндөр байна. Энэ хандлага эмэгтэй хүн амын хувьд ч адилхан байна. Гэхдээ шилжигч эмэгтэй хүн амын ажил эрхлэлтэнд хамгийн хүчтэй нөлөө үзүүлж байгаа хүчин зүйл нь байршил байхад, насны нөлөөлөл маш бага байгаа юм.

### Ном зүй

1. НХХЯ, НҮБХАС, ХАССТ. “Монгол Улсын хүн амын дотоод шилжих хөдөлгөөний микро түвшний судалгаа”, УБ хот, 2000 он
2. НҮБХАС, ҮСГ. “Монгол Улсын дотоод шилжих хөдөлгөөн хотжилт: 2000 оны хүн ам, орон сууцны тооллого дээр үндэслэсэн судалгаа”, УБ хот, 2002 он
3. НҮБХАС, ҮСГ. “2000 оны хүн ам, орон сууцны тооллого: Үндсэн үр дүн”, УБ хот, 2001 он
4. НҮБХАС, ҮСГ. “Хүн амын эдийн засгийн идэвхи: 2000 оны хүн ам, орон сууцны тооллого дээр үндэслэсэн судалгаа”, УБ хот, 2002 он
5. ОУХБ. “Монгол дахь албан бус хэвшил”, УБ хот, 2001 он
6. МУ-ын ЗГ, НҮБХХ. “Монголын хүний хөгжлийн илтгэл”. УБ хот, 1997 он
7. МУ-ын ЗГ, НҮБХХ. “Монголын хүний хөгжлийн илтгэл”. УБ хот, 2000 он
8. МУ-ын ЗГ, НҮБХХ. “Монголын хүний хөгжлийн илтгэл”. УБ хот, 2003 он
9. НХХЯ, НҮБХАС. “Хүн ам ба хөгжил дээд хэмжээний уулзалт”, УБ хот, 2001 он
10. ҮСГ, НҮБХХ. “Хүн амын амьжиргааны түвшний судалгаа”, УБ хот, 1999 он
11. ҮСГ. “Монгол Улсын статистикийн эмхэтгэл”, УБ хот, 2000 он
12. ҮСГ. “Монгол Улсын статистикийн эмхэтгэл”, УБ хот, 2001 он
13. ҮСГ. “Монгол Улсын статистикийн эмхэтгэл”, УБ хот, 2002 он
14. НҮБХАС, МХАХН, ХАССТ. “Нийгмийн статистикийн үндэс”, УБ хот, 2002 он
15. НҮБХАС, МХАХН, ХАССТ. “Монголын хүн амын сэтгүүл”, УБ хот, дугаар 6, 2002 он
16. НҮБХАС, МХАХН, ХАССТ. “Монголын хүн амын сэтгүүл”, УБ хот, дугаар 8, 2003 он
17. UNPFA. “Readings in Population research methodology”, USA, 1993
18. IUSSP. “Basic data needed for the study of urbanization”, Belgium, 1974
19. IUSSP. “The measurement of urbanization and projection of urban population”, Belgium, 1975
20. Layth C. Alwan. “Statistical process analysis”, USA, 2000